

## Говь-Алтай аймгийн бохир усны 2024 оны 02 дугаар сарын тойм

### 1. Хаягдал бохир усны хяналт-шинжилгээ

2024 оны 02 дугаар сарын 21-нд, Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын хаягдал бохир ус цэвэрлэх байгууламжийн орох, гарах 2 цэгээс авсан хаягдал бохир усны сорьцонд хийсэн шинжилгээний дүнгээс үзэхэд цэвэрлэх байгууламжаас гарч байгаа ус 47.2 %-ийн цэвэршилттэй байлаа.

Цэвэрлэх байгууламжын орж байгаа болон цэвэршүүлээд гарч байгаа хаягдал бохир усны сорьцонд хийсэн шинжилгээний дүнг MNS:4943-2015 “Хаягдал ус”-ны стандартад заагдсан хүрээлэн байгаа орчинд нийлүүлэх хаягдал усан дахь бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээтэй харьцуулан 1 дүгээр хүснэгтэд үзүүллээ.

1 дүгээр хүснэгт

Цэвэрлэх байгууламж	Цэг	PH	Ж/б мг/л	БХХ <sub>5</sub> мг/л	ПИЧ мг/л	NH <sub>4</sub> мг/л	NO <sub>2</sub> мг/л	NO <sub>3</sub> мг/л	Цэвэршилт, %
1	2	3	4	5	6	7	8	9	10
Есөнбулаг сумын Төв ЦБ	Орох	8.62	216.4	270	81				47.2 %
	Гарах	7.57	115.2	142.5	69	18.03	0.016	0.41	
<b>MNS4943-2015</b>		<b>6-9</b>	<b>30</b>	<b>20</b>	<b>20</b>	<b>18.45</b>			

Тайлбар: Ж/Б-жинлэгдэх бодис, БХХ<sub>5</sub>-биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч, ПИЧ-Перманганатын исэлдэх чанар, MNS:4943-2015 “Хаягдал ус”-ны стандартад заагдсан хүрээлэн байгаа орчинд нийлүүлэх хаягдал усан дахь бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давсан үзүүлэлтүүдийг тодруулав.

Шинжилгээний дүнгээс үзэхэд Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын хаягдал ус цэвэрлэх байгууламжаас цэвэршүүлээд гарч байгаа усанд биохимийн хэрэгцээт хүчилтөрөгчийн агууламж 7 дахин, перманганатын исэлдэх чанарын агууламж 4 дахин, жинлэгдэх бодисын агууламж 7 дахин бохирдолтой байна.

Дүгнэлт: Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын хаягдал бохир ус цэвэрлэх байгууламж газрын хаягдал ус ЦБ-ийн цэвэрлэгээний чанар 47.2 % байгаа нь хангалттай цэвэршүүлэхгүй байгааг харуулж байгааг ба цэвэршүүлээд гарч байгаа ус MNS:4943-2015 “Хаягдал ус”-ны стандартад заагдсан хүрээлэн байгаа орчинд нийлүүлэх хаягдал усан дахь бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ /ЗДХ/-ээс 4-7 дахин давсан бохирдолтой усыг хүрээлэн байгаа орчинд нийлүүлж байжээ.

БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ